



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

133 /133/

2021.09.13

ҮЙЛ ЯВДАЛ



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫНХАН ТЭМЦЭЭНИЙГ ӨНГӨЛЛӨӨ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит буудлагын тэмцээн Хужирбулан дахь Зэвсэгт хүчний Сургалтын төвд энэ сарын 10-12-ны хооронд явагдлаа. Төрийн цэргийн болон хууль сахиулах 12 байгууллагын 120 гаруй тамирчин өрсөлдсөн тус тэмцээний мэргэн буудагчийн хосын төрөлд ЗХЖШ тэргүүн байр, БХЯ дэд байр, ТЕГ гутгаар байр, гар бууны төрөлд ТЕГ тэргүүн байр, ЦЕГ дэд байр, ЗХЖШ гутгаар байрыг тус тус эзэллээ. Мөн холимог буудлагын төрөлд ЗХЖШ, ТЕГ, ХХЕГ, карбины төрөлд ТЕГ, ЦЕГ, ТТХГ эхний байруудад шалгарав. Тэмцээний хамгийн сонирхолтой төрөл болох мэргэн буудагчийн

биатлоны тэмцээнд ЗХЖШ, БХЯ, ТЕГ эхний 3 байрыг тус тус эзэлсэн юм. Ийнхүү нийлбэр оноогоор ТЕГ өнгөлж, ЗХЖШ, БХЯ удааллаа. Энэхүү тэмцээнд БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд өөрсдийн цэц мэргэнээ сорин баг, тамирчдыг идэвхтэй оролцохыг уриалж байв.

Тус тэмцээн нь Монгол Улс үндэсний эрхчөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, орчин цагийн Зэвсэгт хүчний 100, Цагдаагийн байгууллагын 100, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн тэгш ойнууд тохиосон жил зохион байгуулагдсанаараа онцлогтой юм.

Түүхэнд энэ өдөр

2004 он:

Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Энхийг дэмжих ажиллагааны ар талын төлөвлөлтийн семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.00	2,855.00
EUR	3,322.0	3,422.0
CNY	440.0	444.90
RUB	38.00	40.80
JPY	25.45	26.32
KRW	2.31	2.53

ЗУРХАЙ

2021.09.13 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 7/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ДӨРВӨН НОГООН ХӨХ ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингих:

06.27-19.10

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Гал

Аргын тооллын 9 дүгээр сарын 13, Сумъяа гараг. Билгийн тооллын 7, Эрхтний тэнгэрт одтой, хөх хулгана өдөр. Өдрийн наран 6 цаг 27 минутад мандан, 19 цаг 10 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лусыг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаан үйл төлгөө тавих, морь уралдах, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үрэгзлэх буюу засуулахад тохиромжгүй.

ЭРДЭМТЭН СУДЛААЧИД ЦАХИМААР ЧУУЛАВ

ОХУ-ын Хүүхэд залуучуудын цэрэг-эх оронч хүмүүжлийн "Юнармия" хөдөлгөөний Буриад Улс дахь салбарын санаачилгаар Дайнд оролцогчдын Монголын хороо, Ахмад дайчдын "Улаан одхон" сонинны зөвлөлөөс хамтран зохион байгуулсан "Дэлхийн хоёрдугаар дайны ялалтын ач холбогдол XXI зуунд" Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эрдэмтэн судлаачдын Эрдэм шинжилгээний цахим бага хурал боллоо.

Хурлыг нээж ОХУ-ын Буриад Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд В.А.Поздняков хэлсэн үгэндээ "Дэлхийн хоёрдугаар дайн дуусаад 76 жил өнгөрсөн ч хор уршиг нь өдгөө ч арилаагүй байна. Зөвхөн Буриадаас гэхэд 12000 орчим залуу дайнд мөрдсоноос Халхын голын дайнд 2000 цэрэг эрс амь үрэгдсэн тоо баримт байдаг. Сүүлийн жилүүдэд эрэн хайх отрядынхон 201 дайчны амь үрэгдсэн газрыг тодруулж хүндэтгэл үзүүлсэн талаар дурдав.

Дайнд оролцогчдын Монголын хорооны тэргүүн, бэлтгэл хурандаа Г.Лундэн бага хурлын ажиллагаанд амжилт хүсээд, тус байгууллага 1970-аад онд байгуулагдсанаасаа хойш 1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайн, 1943-1948 онд Баруун хилийн тулгаратад оролцсон ахмад дайчдын гавьяаг мөнхжүүлэх, тэдний үлгэр дуурайлаар залуу үеийг хүмүүжүүлэхэд ажлаа чиглүүлж ирснийг тэмдэглэсэн юм.

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Цэргийн атташегийн туслах Наранмандал бага хуралд оролцогчдод мэндчилгээ дэвшүүлээд "Өнөөдөр бол дэлхийн хүн төрөлхтөн үүрд дурсах учиртай өдөр юм. Одоогоос 76 жилийн өмнө дэлхийн дахины бүх хүмүүсийн хамтын хүчин чармайлтын үр дүнд Японы милитаризм бууж өгснөө зарласан. Азийн байлдааны талбарт аугаа ялалт байгуулсан нь фашизмын эсрэг дайны бүх ялалтын чухал нэгэн хэсэг юм" гэж онцлон дурдлаа.

"Байгалийн чанад дахь цэргийн фронт Манжуурын давшилтын ажиллагаанд" сэдвээр түүхийн ухааны доктор Д.Л.Доржиев илтгэл тавьсан юм.

Тэрээр Зөвлөлт, Монголын цэргийн 25 өдрийн эрчимтэй давшилтын үр дүнд Зүүн хойд Азид дарангуйллаа тогтоогоод байсан Квантуны армийн бэхлэлтийг эзлэн авч Япон Улс дайнд бууж өгөх гэрээнд гарын үсэг зурахад томоохон түлхэц үзүүлсэн гэв.

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн секторын дарга, доктор, профессор, бэлтгэл хурандаа Г.Мягмарсамбуу "1945 оны Чөлөөлөх дайнд БНМАУ-ын оролцоо" илтгэлдээ Японы цэргийн эсрэг Манжуурын давшилтын ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрээс эхлүүлсэн нь цэрэг стратегийн таатай нөхцөлийн нэг болсон бөгөөд үүгээрээ манай улс Дэлхийн хоёрдугаар дайны ялалтад хувь нэмрээ оруулсан" гэсэн санааг дэвшүүлсэн.

"Дэлхийн хоёрдугаар дайны сургамж" илтгэлдээ Буриадын Улсын Их Сургуулийн багш, түүхийн ухааны доктор, бэлтгэл дэд хурандаа Д.Д.Намнанов "Орчин үед өнгөрсөн түүх, тэр тусмаа асар их үнээр олдсон дайны ялалтын үнэ цэнийг бууруулах гэсэн увайгүй үйлдэл гарах болсон"-ыг онцлоод амь үрэгдсэн сүүлчийн дайчны нэр алдрыг нэхэн тодруулж, дурсгалыг нь мөнхжүүлснээр аливаа дайн байлдааныг дууссанд тооцох учиртайг санууллаа.

Доктор, дэд профессор, бэлтгэл дэд хурандаа Лха.Баяр "Монгол ардын хувьсгалт цэрэг Манжуурын ерөнхий давшилтад" илтгэлдээ "Чөлөөлөх дайнд 21300 гаруй бие бүрэлдэхүүнтэй оролцсон Монгол Ардын цэрэг байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд олон зуун километрийн марш үйлдэж, Зөвлөлтийн цэргийн ангидтай харилцан ажиллагаатайгаар давшилтын ажиллагааг зохион байгуулсан нь монгол цэргийн тэсвэр хатуулж, үүрэг гүйцэтгэх чадавхын томоохон сорилт болсон" гэж тэмдэглэв.

Бага хурлын хэлэлцүүлэгт БХЭШХ-гийн төвийн дарга, доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан урилгаар оролцож, Монгол Улс ЗХУ-ын Улаан армийн фашизмын эсрэг дайнд эд материалын тусламж үзүүлж, милитарист Японы эсрэг дайнд өөрийн цэрэг армийг оролцуулснаар



Дэлхийн хоёрдугаар дайны ялалтад зохих хувь нэмрээ оруулсныг жишээ тоо баримт дурдан ярилаа.

Энэ үеэр 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Төмөрийн Бат-Очирын тухай "Би Малиновскийн фронтын дайчин" бэсрэг баримт киног үзүүлснээр дарийн утаа үнэрлэсэн ахмад дайчны яриа, сонирхолтой дурсамж бага хурлын агуулгыг

улам баяжуулав.

Ийнхүү Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төлөөлөл оролцсон Эрдэм шинжилгээний 2 дугаар бага хурал цэрэг-дайны түүхийн баримтыг судалгааны эргэлтэд оруулж нийтийн хүртээл болгосон, эрдэмтэн судлаачид тухайн сэдвээр санал бодол, байр сууриа солилцсон өгөөжтэй арга хэмжээ боллоо.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
249,983 +2771

ЭДГЭРСЭН
241,325 +1293

НАС БАРСАН
997 +15

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
4871 +83

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
193 +13

ЭДГЭРСЭН
4586 +8

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 223,368,662

Эдгэрсэн

Нийт: 199,873,841

Нас барсан

Нийт: 4,608,597

Үйл явдал

ӨВӨЛ СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАЖ БАЙНА

**Зэвсэгт хүчний
326 дугаар анги**

Тус ангийнхан үндсэн үүрэг гүйцэтгэлтээс гадна өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд засвар, тохижилтын ажлуудыг гүйцэтгэгч компани болон өөрсдийн бие бүрэлдэхүүнийхээ хүчээр өрнүүлж байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр "Цагаан уран хийц" ХХК болон ангиас томилогдсон ажлын хэсэгтэй хамтран ангийн гадна дулааны шугамыг бүрэн сольж шинэчилж байгаа юм.

Мөн ангийн Эрүүлмэндийн төвийг III шатны эмнэлгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах, магадлан итгэмжлэх журмын дагуу бүрэн хэмжээний засварт оруулж эмнэлгийн байраа сэргээн шинэчилж байна. Ингэснээр ангийн бие бүрэлдэхүүнээс гадна Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой юм.

Бүтээн байгуулалтын ажил үүгээр дуусахгүй холбооны албаны бие бүрэлдэхүүн ангийн утсан холбооны кабель, шугамыг сольж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн хүнсний албанаас ангийн туслах аж ахуйг хөгжүүлж, хоолны амт чанар, нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор ангийн байрлалд 0,3 га талбайд 9 нэр төрлийн төмс, хүнсний ногоо тариалан байнгын бие бүрэлдэхүүний хүнсэнд хэрэглэж байна.

Түүнчлэн ангийн "Байнгын байрлалын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ангийн хашааны баруун болон хойд хэсгийг сэргээн сайжруулах ажил явагдаж 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 100 метр хашааг блокоор өрлөө.



ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭНЭЭ АМЖИЛТТАЙ ЭХЛҮҮЛЭЭ



Зенитчин дайчид Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэрэгжлийн спортын тэмцээний амжилттай эхлүүлж гар бууны хурдан буудлагын төрөлд оролцсон хошууч П.Баярхүү хүрэл медаль хүртэж, гар бууны тогтоолтын төрөлд

оролцсон хошууч Б.Анхбаяр 12 дугаар байрт шалгарч багийн нийлбэр дүнгээр нийт 36 ангийн баг тамирчдаас 8 дугаар байр эзэллээ.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР



ЦОХИЛОХ ЗҮРХ БҮХНИЙГ АВАРЪЯ



**Зэвсэгт хүчний
350 дугаар анги**

Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах тэмцээн, уралдаанд тус ангийн алба хаагч нарын бэлтгэл хангагдаж уралдаан тэмцээнд амжилттай хамрагдаж байна. Тэмцээний нээлтийн үеэр тасгийн захирагч, ахлах ахлагч А.Амаржаргал, тасгийн захирагч, ахлагч Х.Алтаншагай нар Марш тактикийн төрлөөр "Цэрэгжлийн спортын мастер"-цол тэмдгээр шагнагдлаа.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 90 дүгээр албан бичгийн дагуу цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтыг ангийн материаллаг баазыг түшиглэн 2021 оны 9 дүгээр сарын 6-11-ний өдрүүдэд явуулсан бөгөөд нийслэлийн 9 дүүргийн 90 гаруй алба хаагч цэргийн анхан шатын сургалт, бэлтгэлд хамрагдлаа.

"ЦОХИЛОХ ЗҮРХ БҮХНИЙГ АВАРЪЯ" аяны хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран сайн дурын үндсэн дээр ангийн алба хаагчид цусаа хандивлан 150 хүний амийг аварлаа.



БАЛЛИСТИК ПУУЖИНГИЙН ТУРШИЛТ БОЛЖЭЭ

Энэ сарын 11, 12-нд Хойд Солонгос улс холын тусгалтай шинэ баллистик пуужин туршсанаа зарлалаа. Хойд Солонгосын төв хэвлэлийн мэдээлсний дагуу өнгөрсөн Бямба, Ням гарагуудад баллистик пуужинг амжилттай туршсан бөгөөд бүтэн хоёр жилийн судалгаа шинжилгээний үр дүн биеллээ оллоо гэж мэдээлжээ. Мөн уг туршилтаар пуужингийн түлш, хөдөлгүүр, маневр, цэнэгт хошуу зэргийн үүрэг гүйцэтгэлт,

ажиллагааг нь судалсан байна. Тус улсын хэвлэлд нэмж дурдсанаар "Тив алгасагч баллистик пуужингийн судалгаа, хөгжүүлэлт амжилттай болж байгаа нь Хойд Солонгосын сүүлийн хоёр жилийн шинжлэх ухааны ахиц дэвшил, хөдөлмөр зүтгэлийг харуулж байна" гэжээ. Баллистик пуужин нь 7580 секундгийн турш нисэж, нөхцөлт траекторуудаа дайран өнгөрч, Хойд Солонгосын эргээс 1500 км-ийн зайд тус улсын усан хилийн дагуу унажээ.

